

# AVALIR<sup>®</sup>

## *Owner's Manual*

*For Those  
Who Appreciate  
Quality, Reliability  
& Performance*

**KIRBY<sup>®</sup>**  
HOME CARE SYSTEM

Kirby-н гэр бүлд тавтай морил! Kirby® гэрийн арчилгаа цэвэрлэгээний системийн худалдан авсанд баярлалаа. Энэ нь зөвхөн вакуум биш, гэр цэвэрлэх иж бүрэн систем юм! Олон цахилгаан хэрэгсэл авч, хувцасны шүүгээгээ цэвэрлэх хэрэгслүүдээр дүүргэхийн тулд мөнгө үрэх шаардлагагүй.

Kirby® гэрийн арчилгаа цэвэрлэгээний системийг ашиглахаасаа өмнө энэхүү заавартай танилцана уу. Асуух зүйл гарвал Kirby-н бие даасан дистрибьюторт хандана уу.

Уг зааврыг хэлний сонголтоор онлайнгаар үзэх боломжтой. Зааврыг өөр хэлээр үзэхийн тулд [www.kirby.com](http://www.kirby.com) хаягаар нэвтэрнэ үү.

**Эсвэл Kirby компанитай доорх хаягаар холбогдоно уу:**

[consumer@kirbywhq.com](mailto:consumer@kirbywhq.com)

1-800-494-8586 (АНУ, Канад)

216-529-6146 факс

[www.kirby.com](http://www.kirby.com)

Kirby компани

Хэнд: Хэрэглэгчтэй харилцах

1920 West 114th Street

Cleveland, Ohio 44102

**Сэлбэг, хангамжийн зүйлс:**

АНУ, Канад

1-800-437-7170

[imd@kirbywhq.com](mailto:imd@kirbywhq.com)

Их Британи

0800-328-1247

Европ

00 800 547 292 72

Австрали

1800 781 556

Өмнөд Африк

0800-203-222

Орос

7 800 500 51 46

7 495 374 72 82

## ГАРЧИГ

|                                                                       |           |
|-----------------------------------------------------------------------|-----------|
| Kirby-н эд ангиуд <sup>®</sup> Гэрийн арчилгааны систем .....         | 6         |
| <b>Ажиллуулж эхлүүлэх .....</b>                                       | <b>11</b> |
| Хэрэгслийг угсрах .....                                               | 11        |
| Цахилгааны залгуур .....                                              | 12        |
| Нэг удаагийн шүүлтүүрийн уут .....                                    | 13        |
| Цахилгаанаас салгаж хэрэгслийг зөөх .....                             | 14        |
| Босоо бариулыг түгжих .....                                           | 15        |
| Хэрэгслийг өргөх .....                                                | 16        |
| Бүс өргөгч.....                                                       | 16        |
| Гадна байрлах суурин уут ба Mini Em-Tor <sup>®</sup> Цуглуулагч ..... | 18        |
| <b>Дээд ба зөөврийн цэвэрлэгч.....</b>                                | <b>19</b> |
| Босоо утасны удирдлага .....                                          | 19        |
| Цэвэрлэх өндрийг тохируулах .....                                     | 20        |
| Tech Drive <sup>®</sup> Цахилгаан туслах хэрэгсэл.....                | 20        |
| Зөөврийн цэвэрлэгчид хувиргах.....                                    | 21        |
| Хивстэй шат цэвэрлэх .....                                            | 22        |
| Матрас цэвэрлэх .....                                                 | 22        |
| <b>Канистр цэвэрлэгч ба холболт бүтээгдэхүүн.....</b>                 | <b>22</b> |
| Канистр цэвэрлэгч рүү хувиргахын тулд Хоолойг залга .....             | 22        |
| Нэмэлт хошуунд нэмэлт хэрэгслийг угсрах .....                         | 24        |
| Үлээгч/Хийлэгч .....                                                  | 26        |
| Зөөврийн цацагч .....                                                 | 27        |
| Зөөврийн шингэнээр цэвэрлэгч.....                                     | 29        |
| <b>Нэмэлт хэрэгслүүд .....</b>                                        | <b>30</b> |
| Олон гадаргын шампуний систем: Хивс.....                              | 30        |
| Олон гадаргын шампуний систем: Хатуу шал.....                         | 37        |
| Хатуу шалтай дэр .....                                                | 44        |
| Шалны өнгөлөгч .....                                                  | 45        |
| Гайхамшигт хөөсөөр цэвэрлэгч <sup>®</sup> Шал өнгөлөгч.....           | 47        |
| Хивс цэвэрлэгч .....                                                  | 49        |
| Турбо хэрэгсэл.....                                                   | 50        |
| Цахилгаан багс.....                                                   | 52        |
| <b>Засвар үйлчилгээ.....</b>                                          | <b>53</b> |
| <b>Гэмтэл илрүүлэх .....</b>                                          | <b>58</b> |

# Аюулгүй ажиллагааны чухал зааварчилгаа

| Баталгаажуулсан:                                                                                                                                                                                             | Kirby загвар ба Нэмэлт хэрэгслүүд:                                                                                                                                                  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  <p>АНУ болон Канадын стандартын холбооноос давхар тусгаарласан цахилгаан хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан.</p> | Avalir: Model G10D Sentria<br>2930** ба 2950** Олон гадаргын шампуний систем<br>2931** ба 2951** Шалны арчилгааны систем<br>2935** Цахилгаан багс<br>2932** Турбо хэрэгслийн систем |
|  <p>Хойд Америкаас гадна: Үндэсний туршилтын газраас зохих журмын дагуу зөвшөөрсөн.</p>                                      | Avalir: Model G10E Sentria 230/240 вольт<br>Avalir: Model G10J Sentria 110 вольт                                                                                                    |

## CE журам хэрэгжилтийн мэдэгдэл

Бид, Kirby өөрсдийн цорын ганц үүрэг хариуцлагын дагуу шаардлагатай тохиолдолд Kirby Загварын G10E Тоос сорогч нь дараах стандарт болон стандартчилсан баримт бичгийн дагуу хийгдсэн гэдгийг мэдэгдэж байна.

IEC 60335-1 (EN 60335-1), IEC 60335-2-2 (EN 60335-2-2), EN 55014-1, EN 55014-2, EN 61000-3-2, EN 61000-3-3, EN 50366 ба EN 62233 Нам хүчдэлийн Удирдамж 2006/95/EC ба EMC Удирдамж 2004/108/EC зэрэг

журамтай нийцүүлэн

CE 95

**KIRBY**

1920 Баруун 114<sup>th</sup> Гудамж, Кливленд АНУ ОН 44102



**УГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ АШИГЛАХААСАА ӨМНӨ ЭНЭХҮҮ ЗААВАРТАЙ ТАНИЛЦАНА УУ. УГ ГАРЫН АВЛАГЫН ЗААВАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СЭРЭМЖЛҮҮЛГИЙГ ЗӨРЧВӨЛ БИЕЙН ГЭМТЭЛ АВЧ БОЛНО. УГ ГАРЫН АВЛАГЫГ ХАДГАЛНА УУ.**

Kirby компанид хандах буюу [www.kirby.com](http://www.kirby.com) хаягаар онлайнаар нэвтэрч Ажиллуулах зааврыг авч болно.

# Аюулгүй ажиллагааны чухал зааварчилгаа

## Аюулгүй ажиллагааны заавар ба Таны хариуцлагын тойм:

- Цахилгаанжсан вакуумыг усанд ашиглаж болох тул уг зааврыг бүрэн дүүрэн уншсан танаас таны болон бусдын аюулгүй байдал хамаарна. Танд асуулт байгаа эсхүл уг зааврын мэдээллийг ойлгохгүй байвал Kirby компанид хандана уу.
- Вакуумтай холбоотой ихэнх осол эндэгдлүүд аюулгүй ажиллагаа, урьдчилсан сануулгын ерөнхий дүрмийг сахиагүйтэй холбоотой байдаг. Та болзошгүй аюулыг мэдэж байх ёстой:
- Kirby компани болзошгүй аюултай холбоотой бүх нөхцөл байдлуудыг урьдчилж мэдэх боломжгүй. Тиймээс уг зааврын сануулгууд бүхнийг хамраагүй байж болно. Зөвхөн энэ гарын авлагад заасны дагуу ашиглана. Зөвхөн Kirby-н санал болгосон дагалдах нэмэлт хэрэгслийг ашиглана. Хэрэв Kirby компаниас санал болгоогүй багаж, журам, ажлын арга, ажиллуулах арга техник ашигласан бол та сонгосон журмаараа бүтээгдэхүүнийг гэмтээхгүй, аюулгүй ажиллуулж, засч, арчилна.

## ▲ АНХААРУУЛГА, Гал түймэр, тогонд цохиулах, гэмтэл бэртэл авах аюул эрсдлийг бууруулахын тулд:

- Цэвэрлэгээ, үйлчилгээ хийхээсээ өмнө БАЙНГА салга.
- Энэхүү хэрэгслийг залгаатай үлдээж ОГТ болохгүй.
- Гадаа эсвэл нойтон гадаргуу дээр хэрэглэж ОГТ болохгүй.
- Гэмтсэн утас, залгууртай ашиглаж ОГТ болохгүй. Цахилгаан хэрэгсэл хэвийн ажиллахгүй, унагасан, эвдэрсэн, гадаа орхисон, усанд унагаасан бол Kirby-н эрх бүхий засварын төвд буцаана уу.
- Утаснаас татах буюу утсаар зөөх, утсыг бариул болгон ашиглах, утсаар хаалгыг хаах, утсыг хурц ирмэг, өнцөгөөс татаж ОГТ болохгүй.
- Утсыг халуун гадаргуугаас хол БАЙЛГА.
- Салгахдаа утаснаас татаж ОГТ болохгүй. Салгахдаа утсыг биш залгуураас татна.
- Залгуур болон цахилгаан хэрэгсэлтэй нойтон гараар ажиллаж ОГТ болохгүй.

- Нүх болон нээлхийд эд зүйл хийж БОЛОХГҮЙ. Нээлхийг бөглөрсөн үед ашиглаж болохгүй, нээлхийн тоос шороо, утас, үх хялгас болон агаарын урсгалыг багасгах өөр бусад зүйлийг цэвэрлэнэ.
- Үс, сул хувцас, хуруу болон биеийн бүх хэсгийг нээлхий болон хөдөлж буй хэсгээс хол байлгана.
- Моторын нүхийг линт, үс, тоос хуримтлагдахаас сэргийлэх.
- Хий зэрэг бусад шатамхай бодисыг авахад ашиглах буюу эдгээрийг агуулсан орчинд ашиглаж ОГТ болохгүй.
- Салгахаас өмнө бүх удирдлагыг унтраана.
- Шат цэвэрлэхдээ илүү анхаарал болгоомжтой байна.
- Хүүхэд ашиглахад зориулагдаагүй.
  - o Kirby-ийн химийн бүх бодисыг хүүхдээс хол байлгана. Эдгээр химийн бодисыг залгих буюу нүдэнд орсон тохиолдолд цочрол үүсгэнэ.

o Европын Холбоонд:

Тухайн хэрэгслийг аюулгүй байдлаар ашиглах болон холбоотой аюул эрсдлийн талаар ойлгуулах зааварчилгаа, чиглэл өгсөн бол 8 болон түүнээс дээш насны хүүхэд, мөн биеийн хүчний, мэдрэлийн болон оюун санааны чадваргүй буюу туршлага, мэдлэг дутмаг хүн уг хэрэгслийг ажиллуулж болно. Уг хэрэгслээр хүүхэд тоглож болохгүй. Цэвэрлэгээ, хэрэглэгчийн засварыг хяналтгүйгээр хүүхдээр хийлгэж болохгүй.

- Kirby® цэвэрлэгээний шийдлийг зөвхөн Олон гадаргын шампуний системд л ашиглах зориулалттай. Kirby® Гэрийн арчилгааны бүтээгдэхүүнүүдийн хэсгийг үз.
- Тамхи, шүдэнз, халуун үнс г.м. шатаж буй эсвэл уугиж буй зүйлийг бүү ав
- Тоосны уут, шүүлтүүргүйгээр бүү ашигла

## Аюулгүйн тэмдэг ба Сануулгын түвшин

- ▲ Энэ бол аюулгүйн дохионы тэмдэг. Үүнийг гэмтэл авч болзошгүй аюулын дохио өгөхөд ашигладаг. **Анхаар! Сэрэмжтэй бай! Та аюулд өртөж болзошгүй байна.**


**ЗӨВХӨН ГЭР АХУЙН  
ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАВ.**

# KIRBY-Н ЭД АНГИУД® ГЭРИЙН АРЧИЛГААНЫ СИСТЕМ

| №  | Хэсэг                                          |
|----|------------------------------------------------|
| 1  | Суурин гадаад уут                              |
| 2  | Уутыг салгах товч                              |
| 3  | Уутны туслах оосор                             |
| 4  | Нэг удаагийн шүүлтүүрийн уут                   |
| 5  | Дээд талын адаптор                             |
| 6  | Жижиг Em-Toi® Цуглуулагч                       |
| 7  | Багсан өнхрүүшийн Гүйцэтгэлийн дохионы гэрэл   |
| 8  | Бүс өргөгч                                     |
| 9  | Агаар гаргах хэсэг                             |
| 10 | Доод зөөвөрлөх бариул                          |
| 11 | Дээд зөөвөрлөх бариул                          |
| 12 | Дээд талын бариул                              |
| 13 | Бариулыг нугалах түгжээ                        |
| 14 | Оройны гэрлийн бүрхүүл                         |
| 15 | Дагалдах түгжээ                                |
| 16 | Моторын нүх                                    |
| 17 | Холбох бар                                     |
| 18 | Цахилгаан хошуу                                |
| 19 | Чичиргээ багасгагч                             |
| 20 | Эрчим хүчний сэлгүүр                           |
| 21 | Tech Drive® Цахилгаан туслах хэрэгслийн педаль |
| 22 | Хөлөөрөө удирдах педаль                        |
| 23 | Бариул салгах товч                             |

Хэрэгсэл ба холбох эд анги

|    |                                       |
|----|---------------------------------------|
| 24 | Олон гадаргын шампуний систем (дурын) |
| 25 | Шал угаагч (дурын)                    |
| 26 | Шалны арчилгааны систем (дурын)       |
| 27 | Хатуу шалтай дэр (дурын)              |



## ХЭРЭГСЭЛ БА ХОЛБОХ ЭД АНГИ

| №  | Хэсэг                                              |
|----|----------------------------------------------------|
| 28 | Нэмэлт Kaddy                                       |
| 29 | Зөөврийн шүршигч                                   |
| 30 | Зөөврийн зөөх бариул                               |
| 31 | Хивс цэвэрлэгч цацах зөөврийн таг                  |
| 32 | Ахуйн хэрэглээний багаж                            |
| 33 | Өсгөгч/бууруулагч багаж хэрэгсэл                   |
| 34 | Сунгах хоолой                                      |
| 35 | Солих бүс                                          |
| 36 | Тоосны багс                                        |
| 37 | Бүрээс цэвэрлэх хошуу                              |
| 38 | Хана ба таазны багс                                |
| 39 | Соролтын хяналтын бариул                           |
| 40 | Нэмж болох нүхний багаж хэрэгсэл                   |
| 41 | Цахилгаан хошуу                                    |
| 42 | Холбох хоолой                                      |
| 43 | Агаар оруулах хамгаалалт                           |
| 44 | Цахилгаан багс (дурын)                             |
| 45 | Турбо хэрэгсэл (дурын)                             |
| 46 | Гайхамшигт хөөсөөр цэвэрлэгч® Шал өнгөлөгч (дурын) |






# AVALIR®

## Хэрэгслийг угсрах

- 1 2 хэсгийг цуг гулгуулж Босоо бариулыг угсарна. Бэхлэхийн тулд утасны дэгээнд бооно.



- 2 Босоо бариулын суурийг хэрэгслийн орой дээрх холболт руу түлхэнэ.



- 3 Гадна байрлах суурин уутан дээрх Уутны түгжээний гогцоог Босоо бариултай холбо.



- 4 Сумнуудыг эгнүүлж Mini Em-Tor® цуглуулагчийг Хий гаргах хэсэг рүү гулгуул. Байранд нь түгжихийн тулд үүнийг хэрэгсэл рүү эргүүл.



- 5 Цахилгаан хошуун дээрх Бүс өргөгч дээрх бариулыг гадагш эргүүлнэ. Сумнууд зэрэгцэх хүртэл үүнийг зүүн тийш эргүүл. Дэгээ нь Цахилгаан хошуун доторх Бүсийг ороож, сунгана.





**6** Урд талыг өргөхдөө Хөл удирдлагын доод талын гишгүүрийг доош дарна. Урд талын гэрлийн бүрхүүлийг өргөнө.



**7** Төхөөрөмжийн урд талын Бэхлэх саваан дээрх Цахилгаан хошууны арын 2 дэгээг суллана. Хошууг хэрэгслийг налуулан дарж, Дагалдах түгжээтэй бэхэлнэ.



**8** Бүс өргөгч дээрх бариулыг гадагш эргүүлж, Бүс өргөгчийг ногоон сум зэрэгцэх хүртэл баруун тийш эргүүлэхэд үүнийг ашиглана. Ингэснээр туузыг хөдөлгөх тул Сойзон ороомог эргэнэ. 17-р хуудсыг үз. Толгойн гэрлийн тагийг доошлуулна.




**9** Нэг удаагийн шүүх уутыг тоос соруулахаас өмнө суурилуулна. 13-р хуудсыг үз.



## Цахилгааны залгуур

Төхөөрөмжийн ард байрлах Цахилгааны залгуурыг дарж унтрааж, асаана.



## Нэг удаагийн шүүлтүүрийн уут


Дээд зэргээр ашиглахын тулд зөвхөн Kirby® нэг удаагийн шүүлтүүрийн уутыг ашиглах ба бохир ДҮҮРЭН гэсэн шугамд хүрэхэд тэдгээрийг соль. Нэг удаагийн шүүлтүүрийн уутыг тоос соруулахын өмнө хийнэ.

### Ашигласан нэг удаагийн шүүлтүүрийн уутыг авахын тулд:

- 1 Хэрэгслийг унтраа. Ханын залгуураас цахилгааны утсыг салга. Гадна байрлах суурин уутыг задал. Нэг удаагийн шүүлтүүрийн уутыг бэхэлсэн картон картыг эргүүлээд өргөж гаргана.


▲ Шүүлтүүрийн уутыг байрлуулалгүй тоос сорогч хэлбэрээр бүү ашигла.

▲ Нэг удаагийн шүүлтүүрийн уутыг солихын өмнө цахилгааны утсыг ханан дахь залгуураас салгаад мотор, сэнсийг зогсооно.




### Нэг удаагийн шинэ шүүлтүүрийн уутыг хийх.

- 2 Гадна талын байнгын уутны ам онгорхой, Дээд талын адапторыг татан гаргаад Нэг удаагийн шүүх уутны картон хавтгай жийргийг дээд талын адапторт налуулан байрлуулна.



- 3 Картон хавтгай жийргийг Дээд талын адапторын хавтгай гадаргууд налуулан тавина.



- 4 Нүүрэн талын дээр байрлах картны самбарын гогцоог нугалж Дээд талын адаптор дээрх бариулд холбоно.


- 5 Уут бэхлэх уяаг Дээд талын адапторын жижиг нүхээр холбож, шон дээгүүр бэхэлсэн эсэхийг шалга.

- 6 Нэг удаагийн шинэ шүүлтүүрийн уутыг Гадна талын байнгын уутанд хийж, цахилгаан товчийг хаана.



## Цахилгаанаас салгаж хэрэгслийг зөөх.


Мотор асаалттай үед хэрэгслийг түлхэж, татах үйлдлийг TechDrive® цахилгаан дэмжлэг хялбаршуулна. Моторыг унтраасан үед хэрэгслийг зөөхөөс өмнө TechDrive цахилгаан дэмжлэгийг саармаг байрлалд тохируулах ёстой.



- 1 Хөл удирдлагын доод талын гишгүүрийг доош дарж хэрэгслийн урд талыг өргөнө.



- 2 Зүүн "N" саармаг гишгүүрийг доош дарж TechDrive цахилгаан дэмжлэгийг саармаг болгоно.



## Босоо бариулыг түгжих

Уг хэрэгсэл зөөвөрлөх, хадгалах босоо бариулыг түгждэг. Бариулыг нугалах түгжээтэй.

▲ Бариулын нугалах түгжээг нээхээс ӨМНӨ бариулыг сайн барь.

### Соруулахад:

Тоос соруулах үед налуу цоожны түгжээ нээлттэй төвийн байрлалд байна.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Хойш татахаасаа өмнө Бариулыг нугалах түгжээг нээ. Эдгээр мэдэгдлийг зөрчвөл шалыг эвдэлж болно.



### Зөөвөрлөхөд:

Хэрэгслийг шалнаас дээш өргөсөн байх үед суурийг байранд нь түгжихийн тулд Бариулыг нугалах түгжээг уутнаас холдуул.



### Хаалганы босгон дээгүүр зөөхөд:

Хэрэгслийн урд талыг хаалганы босго, хивсэн дээгүүр өргөхийн тулд Бариулыг нугалах түгжээг уут руу зөөж, түгжсэн Босоо бариулыг доош дарна.



### Албан бус хадгалах арга:

Босоо бариулыг байранд нь түгжихийн тулд Босоо бариулыг шалны хажуугийн хөндлөн байршил руу доошлуулж, Бариулыг нугалах түгжээг уутнаас холдуул. Хэрэгслийг Чичиргээ багасгагч руу нь босгож, хадгалахын тулд үүнийг хана түшүүл.



## Хэрэгслийг өргөх

Суурийг байранд нь түгжихийн тулд Бариулыг нугалах түгжээг уутнаас холдуул. Хэрэгслийг өргөхийн тулд уутны гарны бариулыг ашигла.



Эсвэл хэрэгслийг өргөхийн тулд бариулын голд байгаа Доод талын зөөх ишийг ашигла.



## Бүс өргөгч

Цахилгаан хошуун доторх өргөх дэгээг Бүс өргөгч эргүүлж, Моторын нүх рүү бүсийг доошлуулна. Үүнийг ингэж ашигладаг:

### 1 Сойзны ороомгийг салгах.

Хэрэгслийг унтраа. Урд талын гэрлийн бүрхүүлийг өргөнө. Бүс өргөгч дээрх бариулыг гадагш эргүүлнэ. Үүнийг ногоон сумнууд зэрэгцэх хүртэл Бүс өргөгчийг баруун тийш эргүүлэхэд ашиглана. Бариулыг хаа. Урд талын гэрлийн бүрхүүлийг хаа.

Энэ байрлалд соруулахад Багсан өнхрүүш эргэхгүй.

⚠ Хэрэгсэл асаалттай байхад Бүс өргөгчийг бүү эргүүл.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Хадгалахаас өмнө Багсан өнхрүүшийг буцааж холбовол Бүс өргөгч дэгээн дээр сунахгүй. Эдгээр мэдэгдлийг зөрчвөл бүсийг эвдэлж болно.



## 2 Багсан өнхрүүшийг холбох:

Хэрэгслийг унтраа. Урд талын гэрлийн бүрхүүлийг өргөнө. Бүс өргөгч дээрх бариулыг гадагш эргүүлнэ. Үүнийг ашиглан Бүс өргөгчийг ногоон сумнууд зэрэгцэх хүртэл баруун тийш эргүүлнэ. Бариулыг хаа. Урд талын гэрлийн бүрхүүлийг хаа.

Энэ байрлалд соруулахад Багсан өнхрүүш эргэнэ.




## Шууд сорж цэвэрлэх

Шулуун сорох цэвэрлэгчээр хатуу шал, хивсэнцэр, тансаг хивсийг цэвэрлэхийн тулд Сойзон ороомгийг салга.

Шулуун сорох цэвэрлэгчийг дан шалан дээр ашиглахдаа Цахилгаан хошууг шаланд хүргэхгүйгээр шаланд аль болох ойртуулна.

Хатуу шал соруулахдаа Tech Drive® цахилгаан дэмжлэгийг хий.

Хатуу шалны нэмэлт хамгаалалт хийх бол нэмэлт Хатуу шалны дэр ашигла. 44-р хуудсыг үз.



## Багсан өнхрүүшийн Гүйцэтгэлийн дохионы гэрэл

Багсан өнхрүүш эргэлдэхэд Цахилгааны хошууны баруун дээд талд байрлах Сойзон ороомгийн гүйцэтгэл заагчийн гэрэл асна.

Сойзон ороомгийн заагч гэрэл тодорхой давтамжтайгаар анивчих буюу асахгүй байвал туузыг буруу холбосон эсвэл туузыг солих шаардлагатай байж болно. 53-р хуудсыг үз.



## Гадна байрлах суурин уут, Mini Em-Tor-г салгах.<sup>®</sup> Цуглуулагч

Mini Em-Tor<sup>®</sup> цуглуулагч Нэг удаагийн шүүх уутанд хүрэхгүй том, хүнд хэсгүүдийг хураана.

- 1 Mini Em-Tor цуглуулагчийн сууринаас бариад хэрэгслээс холдуулж эргүүлээд дээш өргө.



- 2 Гадна байрлах суурин уутны дээд хэсгийг Уутыг суллах товчлуур дээр дарж хэрэгслээс салгана.



- 3 Mini Em-Tor цуглуулагчийн нээлхийг сонин/цаасан дээр байрлуулж, доторх зүйлсийг гаргана. Дуусаад Mini Em-Tor цуглуулагчийг буцааж залгана.

❶ Mini Em-Tor цуглуулагчийг байранд нь найдвартай түгжих ёстой бөгөөд үгүй бол хэрэгсэл ажиллахгүй.


**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Зоос г.м. ижил төстэй хүнд зүйлсийг санаатай соруулж болохгүй. Эдгээр анхааруулгыг зөрчвөл сэнсийг эвдэлж болно.

# Босоо утасны удирдлага

Олон цуврал баригчид утсыг Босоо бариултай холбож байдаг.



- 1** Босоо бариулны суурь, хажууд байрлах баригчид утсыг цохиж оруулж холбо.



- 2** Дээд талын утасны дэгээ дээшээ харсан байрлалд байгаа үед утсыг нэгжийн ард талаар явуулж дэгээн дээрх бариул руу утсыг тойруулж оруул.

**i** Дээд талын утасны дэгээ босоо байрлалд байгаа үед бариулнаас цахилгааны утсыг оруулж салгаж болно. Утсыг доошилсон үед байранд нь түгжихийн тулд дээд утасны дэгээг ашигладаг.



- 3** Хадгалах зорилгоор утсыг дээд болон доод утасны дэгээг тойруулан боож болно.



- 4** Утсыг ашиглахаар салгахын тулд, дээд талын утасны дэгээг эргүүл. Эхний эргүүлэг баригчид үлдэнэ.




## Цэвэрлэх өндрийг тохируулах

Урд талын дугуйн дээр байрлах Хөл удирдлага нь Цахилгаан хошууг дээшлүүлж, доошлуулдаг. Дугаарласан тохиргоонууд нь хивс, шаланд зориулагдсан. Цэглэсэн тохиргоонууд нь нэмэлт хэрэгслүүд болон бусад цэвэрлэх хэрэгцээ шаардлагад зориулагдсан.



- 1 Хэрэгслийг асаа. Цахилгаан хошууг хамгийн бага дээр тохируулахын тулд Хөл удирдлагын дээд талын гишгүүрийг аль болох олон удаа дарна.



- 2 Цахилгаан хошууг хүссэн өндөрт хүртэл өргөхийн тулд Хөл удирдлагын доод талын гишгүүрийг дарна.

Өргөх бүрдээ товших чимээг сонсоно. Хүссэн тохируулгад хүртэл товших чимээг тоолно.

### Өргөх хэрэгсэл

Хамгийн доод байрлал

1 Товшилт

2 Товшилт

3 Товшилт

4+ Товшилт

### Зорилго

Санал болгох: Хивс

Дурын: Ширүүн үстэй хивс

Дурын: Урт ширхэгтэй хивс

Санал болгох: Амьтны

үс авах хошуу, нэмэлт

хэрэгсэл

Хоолой ба холбоос



## Tech Drive® Цахилгаан туслах хэрэгсэл

Мотор асаалттай үед хэрэгслийг түлхэж, татах үйлдлийг TechDrive цахилгаан дэмжлэг хялбаршуулна.

- 1 Хөтөч дээр D гэж тэмдэглэсэн гишгүүрийн хажуу дээр доош дарж TechDrive цахилгаан дэмжлэгийг асаана. Энэ нь хэрэгслийг асаалттай үед хөдөлгөхөд шаардлагатай хүчний ихэнхийг бууруулдаг.



- 2 Саармаг дээр N гэж тэмдэглэсэн гишгүүрийн хажуу дээр доош дарж TechDrive цахилгаан дэмжлэгийг тавина. Энэ нь мотор унтраалттай үед хэрэгслийг түлхэж, татах үйлдлийг хялбаршуулна.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Зөөлөн хавтанцар, хатуу шалыг соруулахаас өмнө Tech Drive цахилгаан дэмжлэгийг саармаг болго. Эдгээр анхааруулгыг зөрчвөл шалыг эвдэлж болно.

## Зөөврийн цэвэрлэгчид хувиргах

Зөөврийн цэвэрлэгч шат, матрасын цэвэрлэгээг хийхэд тохиромжтой богино бариултай босоо вакуум бүрэн ажиллагаагаар хангана.



- 1 Хэрэгслийг унтрааж, салга. Tech Drive-ийн цахилгааны туслах хэрэгслийг Саармаг болго. Гадна байрлах суурин уутыг Уут суллах товчлуур дээр дарж хэрэгслээс сулла.



- 2 Утсыг Босоо бариулаас салга. Босоо бариулын сууринд байрлах Бариул суллах товчлуурыг түлхэж, Босоо бариулыг чигээр нь дээш татаж, ховилоос гарга. (Уутыг харуулаагүй)



- 3 Зөөврийн бариулыг Босоо бариул холбогдсон ховилд оруулна.



- 4 Гадна талын байнгын уутыг хагас нугалж, Уутны түгжээний жийргийг Зөөврийн бариул дээрх ховил руу цахилгааныг дээш харуулж оруулна.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Зөөврийн цэвэрлэгчийг гадарласан тавилгад ашиглахгүй. Эдгээр анхааруулгыг зөрчвөл тавилгыг эвдэлж болно.



## Зөөврийн цэвэрлэгчээр хивс дэвссэн шат цэвэрлэх

Зүүн "N" саармаг гишгүүрийг доош дарж Tech Drive® цахилгаан дэмжлэгийг саармаг болгоно. Хэрэгслийн араас нь тулж хивс дэвссэн шатны гишгүүр дээр байрлуулна. Хэрэгслийг байранд нь байрлуулсны дараа асаа.

⚠ Үс, сул хувцас/үнэт эдлэл, хуруу болон биеийн бүх хэсгийг ажиллаж байхад нь нээлхий болон хөдөлж буй хэрэгслээс хол байлгана.

⚠ Tech Drive® цахилгааны туслах хэрэгслийн гишгүүрийг шат соруулахад саармаг байршилд тохируулна.



## Зөөврийн цэвэрлэгчээр матрас цэвэрлэх

Тоос соруулах үед матрасыг үрчийлгэхээс хамгаалахын тулд орон дээрх матрасын бүрээс эсвэл даавууг орон дээр үлдээ.


Зүүн "N" саармаг гишгүүрийг доош дарж Tech Drive® цахилгаан дэмжлэгийг саармаг болгоно. Толгойн гэрлийн тагийг өргөж, улаан сум нэг шугаманд ирэх хүртэл бүс өргөгчийг зүүн тийш эргүүлж Багсан өнхрүүшийг салга. Толгойн гэрлийн тагийг доошлуулна. Хэрэгслийг матрасан дээр байрлуул. Хэрэгслийг байранд нь байрлуулсны дараа асаа.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Багсан өнхрүүшийг салгаж Tech Drive® цахилгааны туслах хэрэгслийг саармаг болгоод даавууг матрасан дээр үлдээ. Эдгээр анхааруулгыг зөрчвөл матрасыг эвдэлж болно.



## Цахилгаан хошууг салгах: Канистр цэвэрлэгч рүү хувиргахын тулд Хоолойг залга

Өндөр эсвэл жижиг талбайг соруулж, цэвэрлэхдээ канистр цэвэрлэгчийг хоолой, нэмэлт хэрэгсэлтэй болгож системийг ашигла.



**1** Хэрэгслийг унтрааж салгасан байхад Хөлөөр удирдах удирдлагын гишгүүрийг бүхэлд нь доош дар.



**2** Зүүн "N" саармаг гишгүүрийг доош дарж Tech Drive® цахилгаан дэмжлэгийг саармаг болгоно.



**3** Урд талын гэрлийн бүрхүүлийг өргөнө. Бүс өргөгч дээрх бариулыг гадагш эргүүлнэ. Үүнийг Бүс өргөгчийг зүүн тийш сумнууд зэрэгцэх хүртэл эргүүлэхэд ашигла.



**4** Цахилгаан хошууг суллахын тулд Дагалдах түгжээг зүүн тийш эргүүл. Цахилгаан хошууг өргө. Моторын нүхний линт, үс, тоосыг цэвэрлэ.

⚠ Моторын нүх халж болно. Моторын нүхний линт, үс, тоосыг цэвэрлэхээс өмнө хөргө.

⚠ Моторын нүхийг линт, үс, тоос хуримтлагдахаас сэргийл. .



**5** Нэмэлт түгжээний дэгээг Бэхлэх саваан дээр байрлуул. Нэмэлт түгжээний нээлхийг хэрэгсэл рүү дээш түлх. Байранд нь түгжихийн тулд Нэмэлт түгжээг баруун эргүүл. Толгойн гэрлийн тагийг доошлуулна. Хэрэгслийг асаа.

❗ Босоо бариул эсвэл Зөөврийн бариулыг Холбох хоолойтой ашиглаж болно.

❗ Хэрэв Холбох хоолойг холбосны дараа хэрэгсэл ажиллахгүй байвал 58-р хуудсыг үз.



## Нэмэлт хошуунд нэмэлт хэрэгслийг угсрах

Хошуунд хэрэгслийг бэхлэхдээ хошууны жижиг үзүүрийг хэрэгсэл рүү эргүүлэх зуураа зөөлөн түлхэнэ.



## Сунгах хоолой

Нэг эсхүл хоёр нэмэлт сунадаг хоолойг холбо.



## Гадаргууны хошуу

Дан шалан дээр, намхан тавилга доогуур ашигла.



## Тоосны багс

Хүрээлсэн буюу тэгш бус гадаргуугийн тоосыг арилга.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Тоосны багсыг телевизорын дэлгэцэн дээр ашиглаж болохгүй. Эдгээр анхааруулгыг зөрчвөл эд өмч эвдэрч хэмхэрч болно.



## Бүрээсний хошуу

Бүрээстэй тавилга, хивстэй шат, хувцас цэвэрлэх. Машины дотор талыг цэвэрлэх.



## Салгадаг багстай нүх цэвэрлэх хэрэгсэл

Нэмж болох нүхний багаж хэрэгслийг сойзтой ашиглаж булангийн бохир, товчны залаа, радиаторын ороомог, гулгадаг цонхыг цэвэрлэх боломжтой.

Багсыг салгаж цоорхой, нүх, өнцөг, ховил, нарийн онгорхой цэвэрлэхэд ашигла.



## Соролтын хяналтын бариул

Сорох түвшинг тохируулахын тулд Соролтын хяналтын бариул дээрх хавхлагийг гулгуулна.

Доош хүргэхийн тулд Сунадаг хоолойн үзүүрт Соролтын хяналтын бариул ашигла.



## Хана ба таазны багс

Хана, тааз, ханын цаас, бусад гадаргуугийн тоосыг соруулахдаа зөв өнцөг гаргахын тулд Хана, тааз цэвэрлэх сойзыг Сорох удирдлагын хавчаарт бэхэлнэ.

Хаалганы хүрээ, булан, номын тавиур дээрх номын тоосыг соруулахдаа хана болон таазны сойзыг 180° эргүүлнэ.



## Ахуйн хэрэглээний багаж

Машины шалны дэвсгэр цэвэрлэхэд ашиглана.



## Өсгөгч/бууруулагч багаж хэрэгсэл


Жижиг газар, хийлсэн тоглоом, матрасыг цэвэрлэхэд Хий гаргах хэрэгсэл болгож ашиглана.

Хийлэх хэрэгсэл болгож ашиглах бол 26-р хуудсыг үз.



## Үлээгч/Хийлэгч

Хоолойг Гаргах хэсэг рүү залгаж үлээгчийг Kirby системд хувиргана.



- 1 Цахилгаан хошууг салга. 22-р хуудсыг үз. Төхөөрөмжийн урд талын Бэхлэх саваан дээрх Агаар оруулах хамгаалалтын ард дэгээг байршуул. Агаар оруулах хамгаалалтыг хэрэгслийг налуулан түлхэж, Дагалдах түгжээг баруун тийш эргүүлж түгжинэ.



- 2 Дараа нь Гадна талын байнгын уутыг салга. Хэсгийг Уутыг суллах товчлуур дээр дарж салгана. Дараа нь Mini Em-Tor® цуглуулагчийн сууринаас бариад хэрэгслээс холдуулж эргүүлээд дээш өргө.



- 3 Холбох хоолойг Агаар шахах хэсэгт холбоно. Холбох хоолойн том үзүүр дээрх сумыг Агаар шахах хэсэг дээрх заагч сумтай зэрэгцүүл. Байранд нь түгжихийн тулд Холбох хоолойг баруун эргүүл.



- 4 Хийлэгч/Хий гаргах хэрэгслийг залга. Үүгээр тоглоом, хийтэй гудас болон бусад нам даралттай хийлэх боломжтой зүйлсийг хийлэх боломжтой. (1м2 дах агаарын даралт). Хэрэв хэрэгслийг үлээгч горимд шилжүүлсний дараа ажиллахгүй байвал 58-р хуудсыг үз.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл.

Тэсрэлтүүдийн хооронд богино амралттайгаар Хийлэгч/Хий гаргах хэрэгслийг 60 секунд ашигла. Эдгээр анхааруулгыг зөрчвөл мотор халж, сэнсний эргэлдэгч ишийг эвдэлж болно.

## Зөөврийн цацагч

Зөөврийн шүршигчийг зөвхөн Үлээх горимд ашиглана. 26-р хуудсыг үз. Үүнийг ус суурьтай шингэнийг шүршихэд ашигладаг.



- 1 Зөөврийн шүршигч тохируулах. Савыг салгаж,  $\frac{3}{4}$ -ийн хэмжээнд нь шатамхай бус шингэн дүүргэнэ.

Зөөврийн шүршигчийн үзүүрийн хоолойг шүрших бууны их биенд сайн холбосон эсэхийг шалгана. Зөөврийн шүршигчийг Холбох хоолойны төгсгөлд холбох.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Ашиглах явцад Зөөврийн шүршигчийг хазайлгах ёстой бол саванд бага хэмжээний уусмал хийнэ. Эдгээр анхааруулгыг зөрчвөл шингэн асарч, эд өмчийг эвдэлж болно.

⚠ Шүршигчид шатамхай шингэн ашиглаж болохгүй.



- 2 Зөөврийн шүршигчийг хэвтээ байрлалд байрлуул. Хэрэгслийг асаа. Онсыг шахан шатамхай бус уусмалыг сонин руу шүршиж, шүршилтийн хэмжээг шалгана. Шүршилтийн хэмжээг тохируулахын тулд оньсон дээрх удирдлагыг асаа.



- 3 Онсыг бүрэн шахаж, шүршихдээ аажим, шүүрдэх хөдөлгөөн хийнэ.

⚠ Хүний амьсгалын замын систем, нүд, арьсанд сөргөөр нөлөөлөх, гэмтэл үүсгэх шавьж устгах бодис болон химийн бүтээгдэхүүнийг Зөөврийн шүршигчид ашиглаж болохгүй.



## Зөөврийн шүршигчийг цэвэрлэх

**1** Зөөврийн шүршигчийг ашиглаад шууд цэвэрлэ. Савыг хоосол. ЗӨВХӨН савантай бүлээн усаар угаана.

▲ Зөөврийн шүршигчийг шатамхай шингэнээр огт цэвэрлэж болохгүй.



**2** Үзүүрийн хоолойг салгаж, угаа. (Цэвэрлэснийхээ дараа буцаан угсарна)



**3** Хошууны урд хэсэгт байх хоёр түгжээг дарж, татаж гаргаад бүрэн зайл. Савыг усаар дүүргээд буцаан холбож, цэвэрхэн болтол нь усаар шүрш.

## Зөөврийн шингэнээр цэвэрлэгч

Зөөврийн шингэнээр цэвэрлэгчийг бүрэн хэмжээний Олон гадаргын шампуний системээр цэвэрлэх боломжгүй шат, жижиг талбайг шампуньдахад ашиглана.

1 Цэвэрлэх гадаргууг соруул.

2 Зөөврийн шингэнээр цэвэрлэгчийг Зөөврийн шүршигчтэй ижил аргаар угсарна. 27-р хуудсыг үз. Савыг 1-р шугам хүртэл усаар дүүргэнэ. Kirby-н хивсний шампунийг савны 2-р шугам хүртэл хийнэ.

3 Зөөврийн шингэнээр цэвэрлэгчийн тагийг Зөөврийн шүршигчийн үзүүрт бэхэлнэ.

4 Шингэнийг хийхдээ хэрэгслийг асааж, оньсыг татна. Шингэний хэмжээг тохируулахын тулд оньсон дээрх удирдлагыг асаа.

5 Цэвэрлэж байгаа гадаргуу руу шингэнийг шууд шүрш. Гадаргуу дээр тогтсон толбыг зөөлөн, цэвэрхэн, сойз буюу зөөлөн хөвсгөр резинээр арчина. Гадаргууг бүрэн хатаана. Дараа нь бохир, хир буртагтай хуурай үлдэгдлийг цэвэрлэнэ.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Бүрээс, торго, хоргой, хамба хилэн зэрэг гоёмсог даавууг цэвэрлэхдээ Зөөврийн шингэнээр цэвэрлэгч ашиглаж болохгүй. Эргэлзээтэй байгаа бол туршилтын эдлэлийг хэрэглэж үзээрэй. Туршилтын даавууг хатааж, шингэнээр цэвэрлэхийн өмнө шалгана.

6 Ашигласны дараа Зөөврийн шингэнээр цэвэрлэгчийг бүрэн цэвэрлэ. 28-р хуудсыг үз.



## Олон гадаргын шампуний систем

Олон гадаргын шампуний системийг хивс шампуньдаж, хатуу гадаргатай шал цэвэрлэхэд ашигладаг.



## Хивсний шампуний систем рүү хувиргах

Байнга шампуньдаж хивсийг цэвэр байлга. Толбо, тод мөртэй талбайг ойр ойрхон цэвэрлэ. Шампуньдахаасаа өмнө хивсийг бүхэлд нь соруул.

**1** Цахилгаан хошууг салга. 22-р хуудсыг үз.



**2** Дараа нь Гадна талын байнгын уутыг салга. 18-р хуудсыг үз.



**3** Хогийн савыг Олон гадаргаас өргөж, салга. Шампуний систем.



**4** Хивсийг шампуньдахдаа хивсний өнхрүүш ашиглах ёстой. Хивсний өнхрүүш хийсэн бол 8-р алхам руу шилж.

Шаардлагатай бол хивсний өнхрүүш хий. Бариулыг ашиглан Олон гадаргын шампуний системийн хошууны Бүс өргөгчийг ногоон сумнууд зэрэгцэх хүртэл баруун тийш эргүүлнэ.



**5** Олон гадаргын шампуний системийг эргүүлж, Туузыг суллахын тулд дээш татаад Шал угаагчийг салга.



**6** Туузыг Олон гадаргын шампуний системээс хивсний өнхрүүшийн төв дээгүүр гулгуулж, Олон гадаргын шампуний системд оруулна.




**7** Олон гадаргын шампуний системийг асаана. Хуруугаараа туузан дээр дарж байхдаа Бүс өргөгчийг ашиглан улаан сум зэрэгцэх хүртэл зүүн тийш эргүүлнэ. Бүс өргөгчийн дэгээ нь туузыг барьж тогтоон мөн сунгана.



**8** Олон гадаргын шампуний системийн ёроолд дуу намдаагч байрлуулсан эсэхээ шалга. Шаардлагатай бол дуу намдаагч хий.

**САНАМЖ** Эд өмч эвдэрч хэмхрэх эрсдэл. Хивсэн дээр ашиглахаасаа өмнө Олон гадаргын шампуний системийн ёроолд дуу намдаагч байрлуулсан эсэхээ шалга. Ингэхгүй бол эд өмч эвдэрч болно.



**9** Хэрэгслийн урд талыг өргөхдөө Хөл удирдлагын доод талын гишгүүрийг доош дарна.



**10** Олон гадаргын шампуний системийн арын дэгээг Бэхлэх саваанд холбо.



**11** Олон гадаргын шампуний системийг хэрэгслийг налуулан түлхэж, Дагалдах түгжээг баруун тийш эргүүлж байранд нь түгжинэ.



**12** Олон гадаргын шампуний Бариулыг ашиглан Хивс цэвэрлэгч шингэний хошууны Бүс өргөгчийг ногоон сумнууд зэрэгцэх хүртэл баруун тийш эргүүлнэ. Толгойн гэрлийн тагийг доошлуулна.



**13** Хогийн савыг хий.



**14** Шампуний саван дээр Хөөсний шигшүүр ба хөөсний шүүр бий эсэхийг шалга. Хэрэв байхгүй бол хөөс зохих ёсоор гарахгүй.



**15** Шингэний савыг дүүргэж, угаалтууртаа дүүргэх буюу угаалтууртаа суллах боломжтой. Хивс цэвэрлэгч шингэний савны дээд талаас том тагийг суллана. Хөөсний хяналтын хавхлагийг УНТРАА. Савыг бүлээн усаар (халуун биш) доорх хүснэгтийн дагуу дүүргэнэ.

Шампуний савны дээд талын том тагаар Хивсний шампунийг хэмжинэ. Шампуний шилээр биш. Хэт хөөсөрч болох тул зохих тооноос олон таг бүү ашигла.

#### **ТАЛБАЙ УС ШАМПУНЬ**

|       |                          |       |
|-------|--------------------------|-------|
| Жижиг | Шампуний савны 1-р шугам | 1 таг |
| Дунд  | Шампуний савны 2-р шугам | 2 таг |
| Том   | Шампуний савны 3-р шугам | 3 таг |

Шампуний савны том тагийг соль.

**❗** 3-р шугам хүртэл дүүргэсэн уусмал ойролцоогоор 10 x 12 фут (3x3.5м) хэмжээтэй хивс цэвэрлэнэ.

**⚠** Олон гадаргын шампуний системд шатамхай, тэсрэмтгий шингэн ашиглаж болохгүй. Эдгээр анхааруулгыг зөрчвөл гэмтэл авч болно. Жинхэнэ Kirby-н шийдлийг зөвхөн ашиглах



**16** Тохой хоолойг Олон гадаргын шампуний Бариулд сайн холбо.



**17** Систем эсвэл шалан дээрх асарсан шингэнээс сэргийлэх арга хэмжээ авч, Агаар гаргах нүхний дээгүүр Шампуний савны урд талын ёроол дахь нүхийг байрлуул.

Шампуний савыг байранд нь түгжихийн тулд хэрэгсл рүү эргүүл.



**18** Тохой хоолойг Шампуний савны ёроолд холбо.




## Хивс шампуньдах

- 1 Олон гадаргын шампуний систем хамгийн доод байршилдаа очтол Хөлөөр удирдах удирдлагын дээд гишгүүр дээр гишгэ.



- 2 Хөөсний хяналтын хавхлагийг Хивсний тохиргооны байрлалд тохируул. Системийг асаа. Хэрэгслийг нааш, цааш хөдлөхөд хөөс нь суларч багс нь хивсэнд ажиллаж эхэлнэ. Цэвэрлэхэд хялбар болгож нэг удаад хивсэн дээр бага хэмжээгээр шампуньд.

- 3 Хөөсний хяналтын хавхлагийг унтраах байрлалд тохируул. Бүх шампунийг бүрэн ашиглахын тулд шампуньдсан хивсэн дээгүүр олон чиглэлд буц.



